



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Цэцэгмаа

Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegnaab@audit.gov.mn



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ХАНТАЙШИР-ЭРДЭМ ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.АЛДАРСАЙХАН ТАНАА

2025. 02. 21

№

54

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Нийгмийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, 16.5.7, 24 дүгээр зүйлийн 24.4, 41 дүгээр зүйлийн 41.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Албан хаагчдад илүү цагийн хөлс олгохдоо цагийн бүртгэлээс зөрүүлэн 1,060.9 мянган төгрөг илүү, 568.1 мянган төгрөг дутуу олгосон,
- Албан хаагчдад цалин тооцож олгохдоо 1,614.7 мянган төгрөг илүү 2,808.7 мянган төгрөг дутуу олгосон,
- Багш нарын ээлжийн амралтын хоногийн тооцоог хийхдээ ажлын өдрийг буруу тоолсноос 4,203.1 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговор, ажилласан хугацааны цалингийн давхардал үүссэн,
- Санхүүгийн ажилтнуудад 1,256.5 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон,
- Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл болох 10,940.0 мянган төгрөгийг ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэлгүйгээр олгосон,
- Тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан төсөвтэй урсгал засварын зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй 62,421.8 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, гэрээнд тусгаагүй 1,606.2 мянган төгрөгийн хүнсний материалын шууд худалдан авалт хийсэн, 8,204.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй,
- Бэлтгэн нийлүүлэгчийн худалдан авах ажиллагаанд санал болгож шалгарсан үнийн саналд тусгасан үнээс өндөр үнээр 620.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн 62,421.8 мянган төгрөгөөр урсгал завсар хийсэн байна. Босго үнээс давсан төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө бэлтгэхдээ худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулах шаардлагатай байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын А/80 дугаар тушаалын дагуу математик, англи хэлний цахим сургалтын хөтөлбөр хэрэгжиж гэрээний дагуу патентын эрхийн төлбөр 9,145.2 мянган төгрөг шилжүүлж шууд зардлаар тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын төсөв захирагч 1 зорилго 5 зорилт хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, аймгийн Боловсролын газраас биелэлтийг 96.4 хувь гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГҮНЖИДМАА

Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
 Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	288,084.9	250,124.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,621,568.0	1,594,946.1
Нийт хөрөнгийн дүн	1,909,653.0	1,845,070.2
Нийт өр төлбөрийн дүн	22,804.7	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,886,848.3	1,845,070.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,909,653.0	1,845,070.2
Үйл ажиллагааны орлогын дүн	2,013,701.9	2,512,831.9
Үйл ажиллагааны зардлын дүн	1,907,302.1	2,554,610.1
Үйл ажиллагааны үр дүн	106,399.8	(41,778.1)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	106,399.8	(41,778.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,780,448.5	1,886,848.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Тайлант оны үр дүн	106,399.8	(41,778.1)
Эцсийн үлдэгдэл	1,886,848.3	1,845,070.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,951,274.1	2,445,614.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,745,896.8	2,438,896.3
Үйл ажиллагааны ЦМГ	205,377.4	6,717.9
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(44,827.3)	(69,965.4)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	160,550.1	(69,965.4)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,375.1	235,572.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	235,572.0	570,999.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,625,975.4	2,507,111.2
Урсгал зардал	2,625,975.4	2,507,111.2
Хөрөнгийн зардал	-	-



Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 30,999.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 1,750.5 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийг үлдэгдлээр тайлагнасан,
- Барилгын засварын материал дансанд биет тооллого хийхэд тайланд онд барилгад суугдсан 16,649.3 мянган төгрөгийн хаалга, цонх, хашаа хайсыг бараа материалын үлдэгдлээр тайлагнасан,
- Туслах үйл ажиллагааны орлогыг дансны ангилал зөрүүлэн төсвийн урамшууллаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 87,100.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 87,100.5 мянган төгрөгийн 9 зөрчил² илэрснээс, 10,876.0 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 76,224.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 4 албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах 1 зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт

1. Албан хаагчдад илүү цагийн хөлс олгохдоо цагийн бүртгэлээс зөрүүлэн 1,060.9 мянган төгрөг илүү, 568.1 мянган төгрөг дутуу олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дахь заалт "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэж заасантай нийцэхгүй иж бүрэн байх, үнэн зөв байх нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг төсвийн орлого болгох, дутуу олгосон нэмэгдлийг буцаан олгох төлбөрийн акт тогтоосон.

2. Албан хаагчдад цалин тооцож олгохдоо 1,614.7 мянган төгрөг илүү 2,808.7 мянган төгрөг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй иж бүрэн байх, үнэн зөв байх нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг төсвийн орлого болгох, дутуу олгосон цалинг буцаан олгох төлбөрийн акт тогтоосон.

3. Багш нарын ээлжийн амралтын хоногийн тооцоог хийхдээ ажлын өдрийг буруу тоолсноос 4,203.1 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговор, ажилласан хугацааны цалингийн давхардал үүссэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй иж бүрэн байх, үнэн зөв байх нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

4. Бэлтгэн нийлүүлэгчийн худалдан авах ажиллагаанд санал болгож шалгарсан үнийн саналд тусгасан үнээс өндөр үнээр 620.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй иж бүрэн байх, үнэн зөв байх нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Санхүүгийн ажилтнуудад 1,256.5 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

ГАА-2024/164/НА-СТА-ТШЗ



2. Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл болох 10,940.0 мянган төгрөгийг ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэлгүйгээр мянган төгрөг олгосон нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралт "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2 дугаар зүйл "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайл, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9 дүгээр хамтарсан тушаалын хавсралт "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийн 8-т "Багш, ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ" гэж заасантай нийцэхгүй иж бүрэн байх, үнэн зөв байх нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй олгож буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан төсөвтэй урсгал засварын зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй 62,421.8 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагааны баримт материалд хүнсний материалын нэр төрлийг бүрэн оруулаагүйгээс 1,606.2 мянган төгрөгийн хүнсний материалын шууд худалдан авалт хийсэн, 8,204.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

гэж заасантай нийцэхгүй иж бүрэн байх, үнэн зөв байх нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг бусад этгээдээс худалдан авч байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журамд заасан хугацаанд хугацаа хангаагүй байхад байгууллагын 30 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулж олон нийтээс хандив авсан ба хандивын тайланг хамт олны хурлаар хэлэлцээгүй нь Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.4-т "Байгууллагын тэгш ойг байгуулагдсан өдрөөс хойш 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн тухайн байгууллагын удирдлага холбогдох шийдвэр гаргаж тэмдэглэнэ", 1.6-т "Салбарын тэгш ойг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон нутгийн байгууллагын тэгш ойг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тэмдэглэнэ" гэж заасантай нийцэхгүй үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандивын тайлангийн орлого, зарлагыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн олон нийтэд мэдээлээгүй, зарцуулалтад нь дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, хуульд заасан журмыг зөрчин ой тэмдэглэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:


1. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын байгууллагад тайлагнахдаа 2,191.2 мянган төгрөгийн цалингийн сан илүү тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын байгууллагад илүү тайлагнасан цалинг залруулж үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХЭЦ сургууль	3	30.9			3	30.9	3	30.9				
Дүн	3	30.9			3	30.9	3	30.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		ХХБ-д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХЭЦ сургууль	8	87.1	4	10.9	3	76.2	1		-	-	-	-
Дүн	8	87.1	4	10.9	3	76.2	1		-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ХЭЦ сургууль	1	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-
-Нийт дүн	9	87.1	4	10.9	4	76.2	1		-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-